

Зөвлөмжийн биелэлт

2019-06-04

д/д	Зөвлөмж	Биелэлт
1	Санхүүгийн албаны үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, батлагдсан сар улиралын хуваарьт нийцүүлж төсвийн санхүүжилт зарцуулалтын эрх олгож байх	Сангийн сайдын 73-р тушаалыг хэрэгжүүлэн санхүүжилтыг ЗЭБ1 маягт хөтлөн төсвийн төвлөрүүлэн захирагчаар хянуулж санхүүжилт олгож байна
2	Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэх, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, ажил үүргийн хуваарийг оновчтой хуваарилах	ЗГСУМС-д шивэгдсэн гүйлгээ бүрийг нэг бүрчлэн хянан шаардлага хангахгүй гүйлгээний тайлбарыг системд бичиж буцаан залруулах эсвэл цуцлах гэх мэт арга хэмжээ авч бүртгэл хөтлөн ажиллаж байна
3	Санхүүгийн албаны нягтлан бодогч нарын хариуцсан байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж , мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, байгууллагын төсвийн эрх захирагч нарыг санхүүгийн мэдээллээр хангах	Төсвийн 6 байгууллагын төсвийн шууд захирагч нарт болон нягтлан бодогч нарт Сангийн сайдын 2013 оны 73, 2018 оны 134, 301,228,318-р тушаал, Засгийн газрын 2018 оны 264-р тогтоолыг тус тус сумын удирдах ажилтаны шуурхайн хуралдаан дээр танилцуулан цаасаар хэвлэж өгсөн. Мөн биечлэн болон утсаар, цахимаар холбогдон тухай бүр арга зүйгээр хангах харилцан зөвлөлдөх гэх мэт мэдээ мэдээллээр хангаж байна
4	ЗГСУМС-ийн доголдлыг арилгах талаар холбогдох байгууллагуудад саналаа тухай бүр хүргүүлэх	ЭМТ-н нэр хуучин хүн эмнэлэг нэрээр байсныг солиулахаар улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарын хамт аймгийн СТСХ-т 2019 оны 02-р сард хүргүүлсэн
5	Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь үнэн зөв хүлээн авч хянаж нэгтгэх, ЗЭБ-1 маягтыг үнэн зөв хөтлөх, сар бүрийн маягтыг бүрэн баталгаажуулах	Байгууллагуудаас хуулийн хугацаанд мэдээг авч нэгтгэж байна. ЗЭБ-1 маягтыг тухай бүр төсвийн төвлөрүүлэн захирагчаар батлуулан санхүүжилт олгож байна
6	Нэмэл санхүүжилтын эрх олгохдоо эрх хүссэн байгууллагаас зохих журмын дагуу бичиг баримтыг бүрдүүлсний үндсэн дээр эрх нээж олгож байх	Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалын 7.2 заалтаар /албан тоот орлогын эх үүсвэрийн шийдвэр, зарцуулах тушаал, шийдвэр, төсөв орлогын хуулга зэрэг баримтын үндсэн дээр эрх олгох хүсэлтыг

		аймгийн төрийн санд илгээж байна
7	Санхүүгийн албанд ашиглагдаж буй тамга, тэмдгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг зохих журмын дагуу хэрэгжүүлэх орчин нөхцлийг хангуулах	Санхүүгийн 2 өрөөг болон бүх албан хаагчдын өрөөг лац ломботой болгосон.
8	ЗГСУМС-д нэвтрэх эрхийг түр шилжүүлсэн тухай аймгийн СТСХ-т албан бичгээр мэдэгдэх, нууц үгийг тухай бүр шинэчлэн солих	Албан бичгээр мэдэгдэж байна.Нууц үгийг тухай бүр сольдог.
9	Сумын хэмжээнд төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллах	2019 оны сарын ажлын төлөвлөгөөнүүдэд тусгагдсаны дагуу 3-р цэцэрлэг, Соёлын төвийн 1,2-р сарын , ЗДТГ, ЭМТ-ийн 3,4-р сарын санхүүгийн баримтанд түүвэрчилсэн байдлаар хяналт хийж арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөн нягтлан бодогч нартай албаны дотоод хурал хийж хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаж байна